

Долоо хоног тутмын мэдээ мэдээлэл - Монголын Мянганы сорилтын сан

№4 (3)

2021.08.09

УС ГҮН ЦЭВЭРШҮҮЛЭХ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ГЭРЭЭНД ГАРЫН ҮСЭГ ЗУРЛАА



Компакт гэрээний санхүүжилтээр барьж байгуулах хамгийн анхны, хамгийн том дэд бүтцийн бүтээн байгуулалт болох Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийг байгуулах, СКАДА систем суурилуулах ажлын гэрээг 2021 оны 8 дугаар сарын 02-ны өдөр үзэглэлээ. Гэрээнд Монголын МСС-г төлөөлж Гүйцэтгэх захирал Э.Содонтогос, гэрчээр Гүйцэтгэх захирлын орлогч С.Зоригт, Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан МАПА группийг төлөөлж Төслийн захирал Омер Исикман, гэрчээр Төслийн менежер Сулэйман Баяхан гарыг үсэг зурав. МАПА групп нь дэд бүтцийн бүтээн байгуулалт, тэр дундаа усны болон нисэх буудлын барилга байгууламж, сэргээгдэх эрчим хүч, зочид буудал, зочлох үйлчилгээний салбар болон Европ, Ойрхи Дорнод, Зүүн Ази, Африкийн орнуудад агаарын тээврийн салбарт үйл ажиллагаа явуулж, дэд бүтцийн 200 гаруй төслийг амжилттай хийж гүйцэтгэсэн Турк улсад төвтэй олон улсын тэргүүлэх барилга угсралтын компаниудын нэг юм.

[Эх сурвалж: Монголын МСС](#)

ГЕРМАНЫ “ФИХТНЕР ВАТЕР ЭНД ТРАНСПОРТЭЙШН” КОМПАНИТАЙ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭНД ГАРЫН ҮСЭГ ЗУРЛАА



гарын үсэг зурав.

Компакт гэрээний санхүүжилтээр хэрэгжүүлэх Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр байгуулах төслийн хүрээнд дахин боловсруулсан ус дамжуулах шугам хоолойн нарийвчилсан зураг төсөл боловсруулах Зөвлөх үйлчилгээний гэрээг 2021 оны 8 дугаар сарын 04-ний өдөр цахимаар үзэглэлээ. Гэрээнд Монголын МСС-г төлөөлж Гүйцэтгэх захирал Э.Содонтогос, гэрчээр Гүйцэтгэх захирлын орлогч С.Зоригт, Зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчээр шалгарсан Холбооны Бүгд Найрамдах Герман улс (ХБНГУ)-ын “Фихтнер Ватер энд Транспортэйшн” компанийг төлөөлж тус компанийн Ази, Номхон далайн бүсийн Бизнесийн хөгжил хариуцсан Гүйцэтгэх захирал Александр Бом, гэрчээр инженер Торбен Андерсен нар

[Эх сурвалж: Монголын МСС](#)


ХӨВСГӨЛ НУУРЫН ЭКОСИСТЕМИЙН БОХИРДЛЫН ЭРСДЭЛИЙН СУДАЛГАА ХИЙЖ, НУУРТ ЖИВСЭН МАШИН ТЕХНИКИЙГ ТАТАН ГАРГАХ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХАТГАЛ ТОСГОНД АЖИЛЛАЖ БАЙНА



Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Ерөнхий сайд байхдаа гаргасан 117-р захирамжаар байгуулагдсан Хөвсгөл нуурын бохирдлыг бууруулах ажлын хэсгийн даргаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, дэд даргаар Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр ажиллаж ажлын хэсгийн бүрэлдэхүүнд уг ажиллагааг гардан зохион байгуулах Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Бригадын Генерал Г.Ариунбуян болон МУ-ын Ерөнхийлөгчийн байгаль орчин, ногоон хөгжлийн бодлогын зөвлөх Ц.Пүрэвхүү, Хөвсгөл аймгийн засаг дарга Ш.Идэрбаясгалан болон холбогдох албаныхан ажиллалаа. Хөвсгөл нуурын бохирдлыг бууруулах цогц ажлын хүрээнд эхний ээлжид Хөвсгөл нуурт живсэн Сүхбаатар хөлөг онгоцыг татан гарахаар төлөвлөсөн.

[Эх сурвалж: БОАЖЯ](#)

Д.ИХБАЯР: АВТО УГААЛГЫН ГАЗРУУДАД НЭН ТҮРҮҮНД СААРАЛ УС ХЭРЭГЛЭХ ТЕХНОЛОГИЙГ НЭВТРҮҮЛЭХ ХЭРЭГТЭЙ



Нийслэлийн хэмжээнд цэвэр ус хэмнэх, саарал усны хэрэглээг нэмэгдүүлэх инновац технологийн шийдлийг судлан нэвтрүүлэх Ажлын хэсгийг Нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулсан. Тэгвэл тус Ажлын хэсгийн дүгнэлт гарч, олон улсын байгууллагатай хамтран ажиллахаар болжээ. Нийслэлийн Инновац, технологийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч Д.Ихбаяр : Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа авто угаалгын 200 гаруй газар бий. Тэдгээрийн 34 нь л саарал ус хэрэглэдэг. Тиймээс бид 2030 он гэхэд нийслэлийн хэмжээнд саарал усны технологийг нэвтрүүлэхээр төлөвлөсөн. Ингэхдээ эхний ээлжид авто угаалга, ногоон байгууламж, гудамж, талбайн усалгаа, гал унтраах ажиллагаанд саарал усыг хэрэглэнэ.

[Эх сурвалж: www.ikon.mn](http://www.ikon.mn)

ГЭР ХОРООЛЛЫН ХУДГУУДАД УХААЛАГ ТӨХӨӨРӨМЖ СУУРИЛУУЛЖЭЭ



Дорнод аймгийн ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар гэр хорооллын долоон худагт 24 цагийн турш ажиллах ухаалаг төхөөрөмжийг суурилуулжээ. Ийнхүү Хэрлэн сумын нэг, хоёр, дөрөв, 10, 11-р багуудад "Ухаалаг-Ус түгээх байр" байгуулснаар иргэд 24 цагийн турш тасралтгүй хэрэглээний усаа картаар авах боломж бүрдэж байна. Дээрх ажлыг "Шинэ усан сан-5" төслийн хүрээнд хийж хэрэгжүүлж байгаа юм.

[Эх сурвалж: www.montsame.mn](http://www.montsame.mn)

ТОВЧХОН

Усны Газрын захиалгаар Говийн бүсийн Үйлдвэр, уурхайн ус хангамжийг нэмэгдүүлэх ТЭЗҮ, ажлын тайланг "Престиж инженеринг" ХХК гүйцэтгэн 2021.08.03-ны өдөр хүлээлгэн өглөө. [Эх сурвалж: Усны Газар](#)

Усны Газрын Хяналт шинжилгээний хэлтсийн даргаар Я.Болдбаатар, Усны нөөцийн хэлтсийн даргаар Д.Өнөржаргал нар тус тус томилогджээ. [Эх сурвалж: Усны Газар](#)